

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР  
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2022 оны жилийн эцсийн байдлаар/**

2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 2 зорилгын 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2022 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /[unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn)/ цахим системд байршуулсан 2 зорилтын 21 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтад авагдсан 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 70.95 %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- Зорилго 3.2. “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ” гэсэн зорилгын хэрэгжилт 62.0 хувь,
- Зорилго 5.1. “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хэрэгжилт 90.0 хувь,

Хэрэгжилт гаргах нийт төсөл, арга хэмжээний тоо		21
Үр дүнтэй	100%	<u>9</u>
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	<u>2</u>
	70%	<u>2</u>
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	<u>3</u>
	30%	<u>4</u>
Үр дүнгүй	0%	<u>1</u>
Хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	-
Хэрэгжилтийн дундаж		70.95%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт /2022 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

Зорилго	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
		100	90	70	50	30	0	
Зорилго 3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	20	9	1	2	3	4	1	62.0%

Зорилго 5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	1		1					90.0%
Нийт дүн	21	9	2	1	3	4	1	70.95%

**2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт хангалтгүй 7 арга хэмжээ байна. Үүнд:**

- 3.2.10 Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах
- 3.2.12 Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах
- 3.2.13 Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх
- 3.2.14 “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих
- 3.2.15 “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх
- 3.2.16 “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих
- 3.2.17 Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх

Эдгээр 7 арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа буюу 30-50 хувиар үнэлэгдлээ.

**2022 оны жилийн эцсийн байдлаар “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:**

- (3.2.21- Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах арга хэмжээ)

**Дөрөв. Дүгнэлт**

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 70.95 хувьтай үнэлэгдэв.
- Хэрэгжилт хангалтгүй 7 арга хэмжээнээс газрын тосны чиглэлээр 2 арга хэмжээ, уул уурхайн чиглэлээр 5 арга хэмжээ, хүнд үйлдвэрийн чиглэлээр үр дүнгүй 1 арга хэмжээ нь байна. Хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй арга

хэмжээнүүд нь тухайн жилд зарцуулсан хөрөнгө, гүйцэтгэл, санхүүжилт тодорхойгүй байгаа нь биелэлтийн түвшинг үнэлэх, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулахад хүндрэл үүсгэж байна.

#### **Тав. Санал, зөвлөмж**

1. Төсөл, арга хэмжээг хариуцсан нэгжүүд нь төсөвт өртөг, гүйцэтгэл, санхүүжилтийн хэмжээг нарийн тодорхой тайлагнах
2. Цаашид салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах,
3. Нэгжүүд Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, арга хэмжээ нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, хүрэх үр дүнтэй болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, зорилго, зорилт, хүрэх түвшинтэй хэрхэн уялдаж байгааг биелэлт гаргахдаа хамт тайлагнаж байх,
4. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох нэгж, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.
6. Хэрэгжилт хангалтгүй “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар хариуцсан нэгжүүд онцгой анхаарч тусгайлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжих боломжгүй бол бодлогын баримт бичгээс хасуулах санал бэлтгэх

Хянасан:

ХШУДАГ-ын дарга

Б.Мөнхдөл

Танилцуулга боловсруулсан:

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Батнайрамдал  
/2022.12.27/

Төлөвлөгөөний хэрэгжилтэнд ХШУ хийсэн:

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Батнайрамдал

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН  
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ  
/2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР/**

2022.12.27

№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө		Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Эх үүсвэр		
1	2	3	4	5	6	7	8	9
<p><b>Зорилго 3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.</b></p>								
3.2.1	ЗГҮАХ-3.2.3	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулах	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулах	Гүйцэтгэл 45 хувьд хүрсэн байна.	11,166.4	Улсын төсөв Батлагдсан: 10,783.7 Гүйцэтгэл: 10,783.7 Санхүүжилт: 10,783.7	Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50, Галбын говь-50, Бүрхтэй уул-50 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2022.06.02-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 17,787.84 км2 талбай буюу 1.13%, нийтдээ 43.1%-ийг тус судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 6 төслийн судалгааны үр дүнд Мангирт (өнгөт металл P2 зэргээр Cu-2298.94 тн, мөнгө-7.248 тн, алт-2.352 кг, цайр-210 тн, хартугалга-315 тн), Эрдэнэ овоо (Алт шороо P1 зэргээр 65.5 кг), Хуурай сайр (P2 зэргээр алт-224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр алт-1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр алт-80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн), Далан шар уул (P3 зэргээр хром-526526 тн, никель-171515 тн), Дөш уулын төмөр зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг ялгасан. 2022 онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1. Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан. 2. Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-	100%

							ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулсан. 3. Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 нийт 6 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулан, төслүүдийн гүйцэтгэгчийг холбогдох хуулийн хүрээнд шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн. 4. Үр дүнгийн тайлантай болон хээрийн судалгааны ажилтай 33 төслийн 2022 онд гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулан хүлээн авсан.	
3.2.2	ЗГҮАХ-3.2.3	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах	Гүйцэтгэл 70 хувьтай байна.	Гүйцэтгэл 66 хувьд хүрсэн байна.	163.7	Улсын төсөв Батлагдсан: 163.7 Гүйцэтгэл: 163.7 Санхүүжилт: 163.7	1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. 2. Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. 2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг агаарын геофизикийн хэмжилтийн ажилд хамруулсан. 4. Төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран 2022.11.22-нд хүлээн авсан.	100%
3.2.3	ЗГҮАХ-3.2.3	Геохимийн 1:1000000-ны масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулах	Гүйцэтгэл 100 хувьтай байна.	Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна.	100.9	Улсын төсөв Батлагдсан: 125.5 Гүйцэтгэл: 125.5 Санхүүжилт: 125.5	1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км2 талбайг буюу 32.1%-ийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нутаг дэвсгэрийн үлдсэн хэсэгт уг судалгаан ажилд 100% хамруулахаар хэрэгжүүлж эхэлсэн. 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км2 буюу 67.9%-д хээрийн судалгаагаар хамруулан холбогдох дээжлэлтийг авч дууссан. 2. 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулах тайлангын суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн. 3. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 4. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын анхдагч баримт, материалыг ҮГА-тай хамтран 2022.11.11-нд хүлээн авсан.	100%

3.2.4	ЗГҮАХ-3.2.4	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	Гүйцэтгэл 10 хувьтай байна.	Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна.	500.0	Улсын төсөв Батлагдсан: 700.0 Гүйцэтгэл: 656,8 Санхүүжилт: 656,8	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулан, геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.07.08-нд гүйцэтгэгчтэй байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 3. Төслийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.30-нд хүлээн авсан.	100%
3.2.5	ЗГҮАХ-3.2.3	Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх	2 төсөл	6 төсөл	1,300.0	Улсын төсөв Батлагдсан: 2,938.3 Гүйцэтгэл: 2,938.3 Санхүүжилт: 2,938.3	1. 2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геозкологи-2019, ДА геозкологи-2020, ХО геозкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1, Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022 нэртэй төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталж, ажлыг эхлүүлсэн. 2. Төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. 2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 4. ХО геозкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн хээрийн судалгааны ажилд 8-р сард шуурхай хяналтыг хийсэн. 5. ДА геозкологи-2020, ХО геозкологи-2021 төслүүдийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.28-нд, Гео орчин-2022, Гүний хагарал-1 төслийн материалыг 2022.12.01-нд хүлээн авсан.	100%
3.2.6	ЗГҮАХ-3.2.5	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх,	1 төсөл	2 төсөл	1,000.0	Улсын төсөв Батлагдсан: 1,087.3 Гүйцэтгэл: 969.7 Санхүүжилт: 969.7	1. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. 2. ӨТТЭ-1-2021 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан.	100%

		хэтийн төлвийн үнэлгээ өгөх					3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчтэй зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. 5. Дээрх 2 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг УГА-тай хамтран 2022.11.15-17-ны өдрүүдэд хүлээн авсан.	
3.2.7	ЗГҮАХ-3.2.4	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	Гүйцэтгэл 5 хувьтай байна.	Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна.	1,000.0	Улсын төсөв Батлагдсан: 550 Гүйцэтгэл: 271.1 Санхүүжилт: 271.1	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.11.30-нд байгуулж судалгааны ажлыг эхлүүлсэн.	70%
3.2.8	ЗГҮАХ-3.2.3	Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх	1 төсөл	3 төсөл	1,450.0	Улсын төсөв Батлагдсан: 1,749.1 Гүйцэтгэл: 1,749.1 Санхүүжилт: 1,749.1	1. 2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагенийн судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайд баталсан. 2. Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгч хуулийн этгээдтэй геологийн судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10, 2022.07.08-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлыг 2022.11.16-20-ны өдрүүдэд хүлээн авч, баталгаажуулсан.	100%
3.2.9	ЗГҮАХ-3.2.5	Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон	2 төсөл	4 төсөл	3,566.8	Улсын төсөв Батлагдсан: 8,560.0	1. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 болон БӨМ-Алт-2019 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр	100%



		металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх				Гүйцэтгэл: 8,560.0 Санхүүжилт: 8,560.0	тушаалаар, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 2. Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 3. Эрэл үнэлгээ-4-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. Төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг 8-9 дүгээр сард хийсэн. 5. Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.15-21 сард хүлээн авсан.	
3.2.10	МУТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.8	Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах	Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг тусгай хэрэгцээнд авсан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	530,100.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан “Улсын тусгай хэрэгцээ”-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12-р сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдэлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхлүүлээд барилга угсралтын ажил -35%, түр замын ажил -15%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -60%, геотехникийн судалгааны ажил -80%, дээжлэлт шинжилгээ -80%. Тосон-Уул 19, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17,5 л ба 16,7л дээж авч тосны дээж авсан. Тус дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторт илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад улын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 10-р сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил -25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННУ хийх ажил -90% хийгдэж байна.	50%
3.2.11	МУТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.8	Газрын тос боловсруулах үйлдвэрийн	Лицензгүй болон үйлдвэрийн	2020-2021 онд хийж эхэлсэн	288,456.9	Гадаадын зээл, тусламж	Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.12.16-ны өдрийн байдлаар 77.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-	70%

		барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх	хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн лицензтэй байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензтэй байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 60 хувьд хүргэсэн байна.			98,69%, Оффис, сургалтын төв-81%, Хоолны газар-90%, Лаборатори-90%, Эмнэлгийн барилга-84%, Агуулах-63,7%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-57%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. ЕРС-2, ЕРС-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Мега инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс текноложу компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна.	
3.2.12	ЗГҮАХ-3.2.8	Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг	Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг	Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн	-	-	Засгийн газрын 2017 оны 92 дугаар, ТӨБЗГ-ын 2017 оны 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит компанийг байгуулсан. ЗГХЭГ-ын дарга болон УУХҮСайд нарын 2021 оны 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит	30%

		бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах	бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна /20 хувь/.			“Эрчис Ойл” ХХК, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Эрдэнэс метан” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 47 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан УУХҮСайд 2021 оны 03 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн. Газрын тосны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган боловсруулж байна.	
3.2.13	МУТЖҮЧ-4.2.1,4.2.11, ЗГҮАХ-3.2.1	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх	Гүйцэтгэл 10 хувьтай байна.	Гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	1,500.0	Улсын төсөв	2022 оны байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-тай хэвээр байна.	30%
3.2.14	МУТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.7	“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах	Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулсан /5 хувь/.	Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээ барих ажлыг гүйцэтгэнэ	128,663.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	Үйлдвэр технологийн паркийн (ҮТП) авто зам, төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл, төсвийг 100% гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100% гүйцэтгэж, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна. Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц барьж байгуулах ажлын хүрээнд: - Автозам барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 3 дахь удаагийн тендер хүчингүй болсон, 4 дэх тендер зарлахаар ажиллаж байна.	50%

		ажлын хүрээнд дэд бүтэц барих		/100 хувь/.			<p>- Төмөр зам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 дахь удаагийн тендерийг 2022.11.07-нд зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна.</p> <p>- Ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах ажлын тендер хүчингүй болсон. Дахин тендер зарлахаар ажиллаж байна.</p> <p>- Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэхээр болж, ажлын төсөвт өртгийг батлуулах ажил хийгдэж байна.</p> <p>“Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн Засаг дарга нар 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр №000000019 дугаартай газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна.</p>	
3.2.15	МУТЖҮЧ-4.2.11, 3 ГҮАХ-3.2.7	“Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан /1 хувь/.	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженерийн зураг төсөл боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гүйцэтгэлийг 10 хувьд хүргэсэн байна.	670,451.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	<p>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын “China ENFI Engineering” компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>Тус ТЭЗҮ-г үндэслэн Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-ын “Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж” боловсруулсан. Үүний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны газарт 2022.09.22-ны өдөр хүргүүлсэн ба Үнэлгээний хороо байгуулагдаж тендер зарлахаар ажиллаж байна.</p> <p>Валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тус ажлын төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн дүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн “Xinxin Metals” компанийн үйлдвэрлэлийн бүсэд</p>	30%

						<p>явуулахаар төлөвлөсөн. Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 98%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 96%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн.</p> <p>Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн хяналт шалгалтуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба үйлдвэрлэгчийн агуулахаас тээвэрлэхэд бэлэн болоод байна. Гэвч БНХАУ-д үүсээд буй Ковид-19 цар тахлын хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх боломжгүй байгаа тул туршилтын ажлын гүйцэтгэлийн хугацааг 2023.11.10-ны өдөр дуусгах төлөвлөгөөг гүйцэтгэгчээс ирүүлсэн.</p> <p>Тус төлөвлөгөөтэй холбогдуулан Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах туршилтын ажлыг эрчимжүүлэх талаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.10.07-ны өдрийн “Үйлдвэрлэлийн туршилтын ажлын тухай” албан бичгийг БНХАУ-ын “China ENFI engeneering” корпорацийн Ерөнхийлөгч Liu Cheng болон “ENFI судалгаа хөгжлийн институт”-ын захирал Yao liang нарт хүргүүлээд байна.</p> <p>Мөн туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон төсөл хэрэгжүүлэх талбайн бүтээн байгуулалтын ажлыг оновчтой зохион байгуулж, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023 оны I улиралд багтаан бүрэн дуусгахад “China ENFI Engineering” корпорацид дэмжлэг үзүүлэх хүсэлтийг БНХАУ-ын холбогдох төрийн байгууллагад зохих журмын дагуу уламжлах хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2022.11.10-ны өдрийн 01/2938 дугаар албан бичгээр БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Цай ВэньРуйд хүргүүлсэн. “China ENFI engeneering корпораци”-аас 2022.11.15-ны өдөр ирүүлсэн албан бичигтээ туршилтын үйлдвэрийг 2023.05.30-нд барьж дуусган, туршилтын ажлын үр дүнг 2023.06.30-ны өдрийн дотор гаргасан байх тухай албан ёсоор мэдэгдсэн.</p> <p>“China ENFI engeneering корпораци”-ийн зүгээс зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төслийн хөгжүүлэлт, нийт хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний гарцын чиглэлээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа 2022.11.23-ны өдрийн албан бичгээр илэрхийлээд байна.</p> <p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.12.19-ний өдрийн өргөтгөсөн шуурхай хурлаас өгөгдсөн чиг үүргийн дагуу Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар China ENFI</p>
--	--	--	--	--	--	---

							Engineering компанид 2022.12.22-ны өдөр дахин албан бичиг хүргүүлсэн бөгөөд China ENFI Engineering компаниас 2022.12.23-ны өдөр ирүүлсэн албан бичигтээ төслийн хэрэгжилтийг хангах чиглэлээр талууд 2022.12.29 өдрийн 14:00 цагт цахим хурал хийх хүсэлтийг ирүүлсэн. China ENFI Engineering компани болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд Т.Бадрал нарт туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг эрчимжүүлэх асуудлаар 2022.12.23-ны өдөр албан бичиг хүргүүлсэн.	
3.2.16	МУХОХ-2.41, ЗГУ АХ-3.2.7	“Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан /1 хувь/.	Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэсэн байна /100 хувь/.	167,371.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиалгаар “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-ийн боловсруулсан “Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Гэвч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас “Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх”-ээр шийдвэрлэсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2022.11.04-ний өдрийн хуралдаанаар тус ТЭЗҮ-ийг хэлэлцэж, Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу гэрээний хугацааг 2023.03.31-ний өдөр хүртэл сунгах саналыг Эрдэнэт үйлдвэрийн ХОХААБГ-т, Техникийн зөвлөлийн шийдвэрийг гүйцэтгэгч компанид тус тус албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэгч компаниас 2022.11.22-ны өдрийн 038/22 дугаар албан бичгээр Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжид өгсөн тайлбарыг ирүүлсний дагуу гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй 2022.12.14-ний өдөр цахим хурлыг зохион байгуулж ТЭЗҮ-ийг шинэчлэн засварлахаар тохиролцсон байна. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30%	30%
3.2.17	ЗГҮАХ-3.2.1	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн	Гүйцэтгэл 32 хувьтай байна.	Гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	292,181.8	Гадаадын зээл, тусламж	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 46.1%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 69.7%-д хүрсэн.	50%

		парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх						
3.2.19	ЗГҮАХ-3.2.9	Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх	Ажлын хэсэг байгуулж, төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.	Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, байгалийн шавхагдах баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үедээ тэгш, шударга хуваарилах боломжтой болно.	-	-	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичиг, материалуудыг УУХҮСайдын 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлээд байна.	100

3.2.20	ЗГҮАХ-3.2.2	Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 10 хувьтай байна.	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	27,650.0	Гадаадын зээл, тусламж	Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны далд уурхайн 2 налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1199.5 у.м нэвтэрч, /9894,7 м3 уулын цул нураасан уулын ажил хийж 78.9% гүйцэтгэлтэй байна. Уурхайн доод түвшин 1150 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмгийн барилга байгууламжийн ажил 85% гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 50 хувьд хүрсэн. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%.	90%
					11,850.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл		
3.2.21	ЗГҮАХ-3.2.7	Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах	Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженер-геологийн судалгаа хийгдсэн. Үйлдвэрийн барилга баригдсан. Тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн. Гүйцэтгэл 16.4 хувьтай байна.	Гангийн үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийн татан авалт 88 хувьтай байна.	9,000.0	Концесс, төр- хувийн хэвшлийн түншлэл	Дорноговь аймагт “МДМУ” ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил цар тахал, хилийн хорио, үлдэгдэл хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас 2022 оны 12 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн нэмэлт хөрөнгө оруулалтын хувилбаруудыг судалж байна.	0%
<b>Бүлэг 5.Ногоон хөгжлийн бодлого</b>								
<b>Зорилго 5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</b>								
5.1.1	МУТЖҮЧ-3.6.3, 6.2.1, 6.2.4, ЗГҮАХ-5.1.8	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	1973.9 га талбайд техникийн, 634.8 га талбайд	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн	40,000.0	Концесс, төр- хувийн хэвшлийн түншлэл	2022 оны уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 507.7 га-д, биологийн нөхөн сэргээлтийг 306.2 га-д, дүйцүүлэх хамгаалах ажлыг 1388.8 га-д нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. “Оюу толгой” ХХК Ялбаг орчмын 334.57 га, “Эрдэнэт үйлдвэр”	90



			биологийн нөхөн сэргээлт хийсэн.	2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.			ТӨҮГ Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 га талбайд нөхөн сэргээлтийн тендер зарлагдаж сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. Нийслэлийн ЗДТГ-аас Налайх дүүргийн 3-р хороонд нүүрсний олборлолтын улмаас эвдрэлд орсон 40 га газрын нөхөн сэргээх ажлын тендер зарласан. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу 2022 оны уулын ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2-р сард ирүүлдэг. 2022 оны хагас жилийн мэдээлэл гаргах боломжгүй байна.	
<b>ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН</b>								<b>70.95</b>